



СҮХБААТАР аймгийн ЭРДЭНЭЦАГААН сумын СБАХ

ХЭРЭГЖҮҮЛСЭН ХУГАЦАА: 2020 оны 10 сар 15-аас 11 сарын 01

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ТӨГ: 3,000,000

Төсөл хэрэгжсэн газар

Сүхбаатар аймгийн
Эрдэнэцагаан сумын 7-р баг
Дэлийн булаг

ЖИЖИГ ТӨСЛИЙН ТАЙЛАН

Төслийн зорилго

Дэлийн булгийн эхийг малын
хөлөөр дарагдах, бохирдохоос
хамгаалах зорилгоор хашиж
хамгаалах



Төслийн зорилтууд

-Дэлийн булгийг хамгаалах
хашаа хайсыг төмрөөр хийлгэх

-Булгийн эхэнд хурсан элсийг
зөөж тээвэрлэх

-Булгийг хашиж хамгаалах

Үйл ажиллагаа

Булгийн эхийг хашиж хамгаалах
төслийн хүрээнд сумын төвд
төмрөөр хашаа хайс хийдэг хувь
хүнээр 15x15 м буюу нийт 60 м
хашааг хийлгэсэн. Булгийн
эхэнд хурсан элсийг 30 портер
элсийг зөөж тээвэрлэн булгийн
эхийг хашиж хамгаалсан.

Төслийн хөрөнгө оруулалт

Хөрөнгө оруулалтын эх үүсвэр	Санхүүжилт, төгрөг
Төслөөс	3,000,000
Нийт	3,000,000

Хөрөнгө оруулалтын зарцуулалт

Төслийн санхүүжилтийг юунд зарцуулсан талаар доорх хүснэгтэнд мэдээлэл оруулна

№	Хөрөнгө оруулалтын зарцуулалт	Хэмжих нэгж	Тоо	Нэгжийн үнэ	Нийт, төг
	1x2 м хэмжээтэй төмрөн хашаа	Ш	30	40,000	1,200,000
	Элс шороо шавар зөөвөрлөлт 30 портер 10,000-300,000 төг	Портер	30	10,000	300,000
	Ажлын хөлс	5 хүн хүн.хоног	15 хоног	20,000	1,500,000
	Нийт				3,000,000

ТӨСЛИЙН ҮР ДҮН

Төсөл хэрэгжихээс өмнөх үетэй харьцуулахад төсөл хэрэгжснээр гарсан үр дүнгүүдийг тодорхой тоо баримттай, график дүрстэй оруулна. Үүнд:

- ↑ Булгийн эх ямар ч хамгаалагдаагүй малын хөлөөр усны ундрага элс, шороонд дарагдах, өтөгөөр ус бохирдсон байсан бол 15x15 м төмрөн хайс хашаагаар эхийг хамгаалснаар дээрхи асуудал бүрэн шийдэгдсэн
- ↑ Дэлийн булгийн ойр хавьд БАХ-ийн 20 малчин өрхийн 3500 гаруй толгой мал хавар, зун, намрын улиралд уг булгаар ундаалдаг бөгөөд булгийн эх гадны нөлөөгөөр бохирдохоос хамгаалагдсан.
- ↑ Арвижих БАХ-ийн малчдын хүчээр ажлыг гүйцэтгэсэн бөгөөд 5 малчинд ажлын хөлс 1,5 сая төгрөгийн өрхийн орлогод нэмэр тус болсон .

ТӨСЛИЙН ҮР ШИМ ХҮРТЭГЧ

Төслийн үр шимийг Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын 7-р баг Арвижих БАХ-ийн 20 малчин өрхийн 80 гаруй хүн малаараа дамжуулж шууд хүртсэн. Төсөл хэрэгжүүлэгч С.Уранцэцэг малчдаа төлөөлж төслийн үр шимийг ийн хэлсэн “Манай БАХ-ийн 20 өрхийн 3500 толгой малыг ил задгай усаар ундаалах боломжийг олгосон төслийн хамт олонд баярлалаа” гэсэн.

ТӨСЛИЙН ЗОРИУЛАЛТ

Төсөл буцалтгүй хэлбэрээр БАХ-ийн малчин өрхийг дэмжих, бэлчээр усжуулалтыг сайжруулах, булаг шандыг хамгаалах үүднээс төсөл зориулалтын дагуу зарцуулагдсан.